

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах ажиллагаа 2017 оны 6 дугаар сарын 26-ны одор болж онгоров. Сонгуулийн үр дүнд нэр дэвшигчдийн хэн нь ч саналаа огсон нийт сонгогчийн олонхийн санал авагчид тул Сонгуулийн тухай хуулийн 105 дугаар зүйлд заасны дагуу хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулахаар болов.

Иймд тус ЭСЯ-нд санал огохоор бүртгүүлсэн, ООУБЕГ-аас баталгаажуулан ирүүлсэн нэрсийн жагсаалтад багтсан 176 иргэн 2017 оны 7 дугаар сарын 4-ны өдрийн Мягмар гарагт 07.00 – 22.00 цагийн хооронд ЭСЯ-ны байранд оорсдийн гадаад паспорттайгаа хврэлцэн ирж дахин саналаа огно вв.

Жич:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн хоёр дахь санал хураалт явагдах болсонтой холбогдуулан шинээр иргэдийг бүртгэхгвй,

- Сонгуулийн вйл ажиллагаатай холбогдуулан иргэдийн шилжилт ходолгооний бүртгэлийг хаасан байгаа тул тус ЭСЯ-нд бүртгүүлж, баталгаажсан нэрсийн жагсаалтад багтсан иргэд зовхон тус ЭСЯ-нд санал огох боломжтой болохыг анхаарна уу.

Баталгаажсан нэрсийн жагсаалтыг [эндээс](#) харна уу.

Written by stockholm

Wednesday, 28 June 2017 07:34 - Last Updated Wednesday, 28 June 2017 07:36

---

СТОКГОЛЬМ ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
СОНГУУЛИЙН САЛБАР КОМИСС ДУГААР 30